

# **СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

## **Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

### **1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Тайлант сард аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан 1 удаа хуралдаж 8 асуудал хэлэлцэж 7 тогтоол баталлаа. Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан Д.Цогт-Очир, Ж.Отгонхүү нарыг чөлөөлж, намын нэрийн жагсаалтаар дараагийн нэр дэвшигчээр эрэмбэлэгдсэн Л.Энхтөр, О.Баатарцогт нарыг аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцож бүрэн эрхийг зөвшөөрлөө.

Аймгийн Эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хэлэлцэж, 2014 оны үндсэн чиглэлийг баталлаа.

Аймгийн 2013 оны төсөвт тодотгол хийж, 2014 оны төсвийг хэлэлцэн баталлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны ажлын тайланг хэлэлцэж “Хангалттай” үнэлгээ өглөө.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 12 сард 2 удаа хуралдаж 20 асуудал хэлэлцэж 18 тогтоол баталлаа. Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн зарим асуудлаас дурьдвал:

- Аймгийн “Иргэний оролцоо-Төрийн үйлчилгээ” хөтөлбөр, мөн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-ийг тус тус хэлэлцэн баталлаа.
- Аймгийн Аудитын газрын 2013 оны ажлын тайланг хэлэлцэж “Хангалттай” үнэлгээ өглөө.
- Зарим иргэн, аж ахуйн нэгжийг Засгийн газраас жил бүр олгодог “Улсын тэргүүний тариаланч”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, “Улсын сайн малчин” шагналаар шагнуулахаар уламжиллаа.
- Сэлэнгэ аймгийн Мандал сум байгуулагдсны 90 жилийн ойг 2014 оны 7 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэх, Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг байгуулагдсны 70 жилийн ойг 2014 оны 9 дүгээр сард тус тус тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрлөө.
- Зарим иргэдийг төрийн дээд шагналаар шагнуулахаар тодорхойлж Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Хүдэр, Ерөө сум, Бугант тосгонд ажиллаж төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцан ард иргэдтэй уулзаж санал хүсэлтийг сонслоо.

### **2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “Авьяас”, “Ном”, “Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотод Боловсрол Шинжлэх Ухааны Яам, Удирдлагын академийн захиргаа, аймгийн Засаг даргын тамгын газар, боловсролын газар хамтран ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт зориулсан туршлага судлах, чадваржуулах сургалтыг 2013 оны 12 дугаар сарын 2-4-ний өдрүүдэд зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 69 багш хамрагдаж, “Монгени” сургууль, улсын тэргүүний 122-р цэцэрлэгийн туршлага судлаллаа.

“Сэлэнгэ аймгийн хөгжлийн гарц” шилдэг илтгэлийн уралдааныг 2012 оны 4 дүгээр сарын 26-аас 1жилийн хугацаанд зарлаж, 16 их дээд сургуулиудын 109 оюутнууд 99 илтгэлээр ганцаарчилсан болон баг хэлбэрээр оролцож,

шалгаруулалтыг 3 үе шаттайгаар 2013 оны 12 дугаар сарын 6-7-ны өдрүүдэд зохион байгууллаа. Шилдгээр Сүхбаатар сумын харьяат, ШУТИС-ын 3-р курсын оюутан Х.Нямдалайгийн “Байгаль орчны тогтвортой хөгжил ба иргэний ороцлоо” сэдэвт илтгэл шалгарч 1.0 сая төгрөг, Баянгол сумын харьяат Удирдлагын академийн Удирдахуйн ухааны сургуулийн 2-р курсын оюутан Л.Дөлгөөний “Сэлэнгэ аймгийн хөгжлийн гарц” илтгэл 2-р байр эзлэн 800.0 мянган төгрөг, Сүхбаатар сумын харьяат, МУИС-ын Олон улсын харилцааны ангийн 2-р курсын оюутан С.Түвшинзаяа, мөн сургуулийн 2-р курсын оюутан Задгай цагаан нарын “Боловсрол” илтгэл 3-р байрт шалгарч 500.0 мянган төгрөгөөр шагнагдлаа.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймгийн Хилийн мэргэжлийн хяналтын газар хамтран “Импортын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, эрсдэлд суурилсан хяналт” сэдэвт сургалтыг 2013 оны 12 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд Замын-Үүд, Буянт ухаа, Алтанбулаг, Сүхбаатар боомт, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгийн Хилийн мэргэжлийн хяналтын газрын нийт 64 албан хаагч хамрагдлаа.

БНСУ-н Кёнги мужийн Усон хотын дарга Чо Вон Су, захиргааны газрын дарга Сон Жён Ван тэргүүтэй төлөөлөгчид тус аймагт 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр айлчлал хийж, тус хоттой манай аймаг хөдөө аж ахуй, соёл боловсролын салбарт хамтран ажиллаж, туршлага судаллаа.

Тус аймагт Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл шинэчилсэн журмын дагуу Төрийн жинхэнэ албанд анх удаа орох мэргэшлийн шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгууллаа. Тус шалгалтанд туслах түшмэлийн 23, дэс түшмэлийн 23 нийт 46 ажлын байранд 258 хүн бүртгүүлж шалгалт өгснөөс 27 хүн тэнцлээ.

“Улсын Их Хурлын үйл ажиллагааг иргэд олон нийтэд хүргэх нь” сэдэвт сургалтыг аймгийн нийт сумдын Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргаа, Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, иргэдийн төлөөллүүдийг оролцуулан аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгууллаа. Сургалтаар парламентын үүсэл хөгжил, парламентат ёс, зарим улсуудын парламентын тухай болон 1992-2012 оны хооронд байгуулагдсан УИХ-аас хэлэлцэн баталсан хууль тогтоомжууд, одоогийн УИХ-ын байнгын хороо, дэд хороодын эрхлэх асуудал, хууль батлагдах процесс болон УИХ-ын гишүүдээс иргэд олон нийттэй хэрхэн хамтран ажилладаг, хууль тогтоолын төсөлд иргэд санал хүсэлтийг хэрхэн тусгадаг талаар дэлгэрэнгүй мэдээ, мэдээллийг хийлээ.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас “Иргэдээ сонсьё” телевизийн шууд нэвтрүүлэгийг аймгийн төв Сүхбаатар суманд 2013 оны 12 дугаар сарын 28 өдөр орон нутгийн “Миний монгол” телевизтэй хамтран зохион байгууллаа. Тус нэвтрүүлэгийн үеэр иргэдээс нийт 63 санал, өргөдөл, гомол ирснээс 23-ыг газар дээр нь шийдвэрлэж, хариуг өгч, нийт санал өргөдөл гомдлыг шийдвэрлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 370-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн талууд мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын орлогч бөгөөд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт салбар хорооны дарга Н.Батдорж, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Ж.Саранцэцэг, Ажил олгогч эздийн холбооны тэргүүн Н.Энэбиш, Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Энхсайхан нар оролцлоо.

### **Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

#### **1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

## 11-р сарын 30-ний байдлаар

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн орлого	15481041.30	13436842.30	86.8
2	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	12127851.50	10138755.00	83.6
3	Орон нутгийн төсвийн зарлага	50059317.90	45761546.00	91.4
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлага	12850356.90	10980080.50	85.4
	Аймгийн ОНХСангийн зарцуулалт	2635205.00	1803701.40	68.4
	Авто замын хөрөнгө оруулалт	274540.90	175376.10	63.9
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	3560300.00	3560300.00	100.0
5	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	1297525.10	982718.40	75.7
6	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	9449774.30	9028861.10	95.5
7	Засаг даргын нөөц	437158.70	436045.20	99.7

2013 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 86.8 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 75.4 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100.0 хувь тус тус биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 91.4 хувийн биелэлттэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 95.5 хувь, Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 99.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

**2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:**

№	Барааны нэр, төрөл	Хэмжих нэгж	Үнэ, ханш /төгрөгөөр/	
			2012 оны 11-р сар	2013 оны 12-р сар
Нэг.Талх, гурил, будаа				
1	Гурил /1-гурил/	1 кг	900	900
2	Талх /орон нутгийн/ том, жижиг	ш	800, 1800	800, 1800
3	Нарийн боов	1 кг	1800-2300	1800-2300
4	Элсэн чихэр	1 кг	1800	1800
5	Цагаан будаа	1 кг	2200	2200
Хоёр.Мах, махан бүтээгдэхүүн				
6	Хонины мах	1 кг	6800	7000
7	Үхрийн мах	1 кг	7000	8000
8	Адууны мах	1 кг	5700	7000
9	Ямааны мах	1 кг	5700	6500
10	Дотор мах цувдай	1 кг	3500	3500
11	Хиам, чанасан	1 кг	9000	9000
12	Гахайн мах	1кг	7000	7500
Гурав.Сүүн бүтээгдэхүүн				

12	Сүү /задгай/	1л	800	800
13	Сүү /савласан/	1л	1700-1800	1700-1800
14	Тараг /задгай/	1л	1000	1000
15	Хорхой ааруул	1 кг	8000	8000
16	Айраг	1л	-	-
17	Хуурай сүү /орос/	1 кг	4200	4200
18	Өндөг	ш	330-350	330-350
Дөрөв. Бүх төрлийн өөх тос				
19	Ургамлын тос	1 кг	2900-3500	2900-3500
20	Өөхөн тос	1 кг	1200	1200
21	Шар тос	1 кг	6000	6000
22	Масло /задгай/	1 кг	3000	3000
Тав.Хүнсний ногоо				
23	Төмс/Монгол/	1 кг	800	800
24	Лууван	1 кг	1000	1000
25	Манжин	1 кг	1000	1000
26	Байцаа	1 кг	800	800
27	Сонгино	1 кг	2000	2000
28	Өргөст хэмх /Монгол/	1 кг	-	
29	Тарвас /Монгол/	1 кг	-	
30	Өргөст хэмх /даршилсан/	ш	3000-4200	3000-4200
31	Алаг салат /даршилсан/	ш	2100-2500	2100-2500
Зургаа.Тээвэр шатахуун				
32	Бензин А-80	1 л	1540	1540
33	Бензин А-92	1 л	1650	1650
34	Дизель түлш	1 л	1780	1780

### **Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

#### **1.Архивын талаар:**

Аймгийн Төрийн архиваас архиваас Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газрын архив, албан хэрэг хөтлөлт, байгууллагын архивын ORG-AMS программын ашиглалтын байдалтай танилцаж заавар зөвлөгөө өглөө.

Баянгол сумын “ХААН” банк, Жавхлант сумын ахмадын өргөө, Мандал сумын үйлчилгээтэй орон сууцны барилга, Сүхбаатар сумын Хаан банкны тооцооны төвийн өргөтгөлийн зураг, Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн үерийн хамгаалалтын далан сувгийн ажлын зургуудыг хүлээн авч Төрийн архивын хөмрөгт байрлууллаа.

Түнхэлийн Мод бэлтгэлийн аж ахуйн 1960-1982 оны 81 хадгаламжийн нэгж, Номгон сангийн аж ахуйн 1976-1991 оны 131 хадгаламжийн нэгж, аймгийн Усан замын тээврийн захиргаа 1962-1991 оны 130 хадгаламжийн нэгж, аймгийн Ой агнуурын аж ахуйн 1959-1990 оны 193 хадгаламжийн нэгж бүхий баримтуудад иж бүрэн нягтлан шалгалтын ажлыг хийж хадгалах хугацаа дууссан, мэдээлэл, лавлагааны ач холбогдолгүй, эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх шаардлагатай, цахим хэлбэрт шилжүүлэх баримтуудыг олж илрүүллээ.





2013 оны 11 дүгээр сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 827 хүн байсан бол 459 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 440 ажлын байранд 438 хүнийг ажилд зуучлан ажилгүйчүүдийн тоо 842 боллоо.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс Шаамар суманд туршилтын байдлаар эцэг, эх, асран хамгаалагчдад тусгайлан бэлтгэсэн модулын дагуу “Мэргэжил бүхэн сайхан” сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах” өдөр хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр өдөрлөг зохион байгууллаа.

Аймгийн төв Сүхбаатар сумын төрийн болон хувийн хэвшлийн 40 гаруй аж ахуй нэгж байгууллагуудын дарга эрхлэгч нарт Хөдөлмөрийн хэлтсээс хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар сургалт зохион байгууллаа.

### **6.Хүүхэд залуучуудын талаар:**

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Дэлхийн зөн олон улсын байгууллага хамтран “Хөгжилд хүүхдийн оролцоо V” аймгийн хүүхдийн чуулганыг Дбайгууллагын Сэлэнгэ Орон Нутгийн Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран 2013 оны 11 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Монголын нийгмийн ардчилсан социалист залуучуудын холбоо хамтран “Үнсгэлжин 2013” хувцас загварын маскарат шоу уралдааныг 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгууллаа.

#### **Тав.Хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:**

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрийн газар, “Сэлэнгэ хүнсний ногоо”-ны ассоциаттай хамтран “Хаягдал бүтээгдэхүүнээр хүлэмж барих арга, ач холбогдол” сэдэвт сургалтыг аймгийн төв  $\tilde{N}_{\zeta} \delta \alpha \alpha \delta \alpha \delta \tilde{n} \tilde{o} \tilde{i} \tilde{a} \tilde{i} \tilde{a} \tilde{c} \tilde{i} \tilde{o} \tilde{e} \tilde{i} \tilde{i} \tilde{a} \tilde{a} \tilde{e} \tilde{x} \tilde{o} \tilde{o} \tilde{e} \tilde{l} \tilde{a} \tilde{a}$ .

$\tilde{N}_{\zeta} \delta \alpha \alpha \delta \alpha \delta \tilde{n} \tilde{o} \tilde{i} \tilde{a} \tilde{i} \tilde{a} \tilde{a} \tilde{d} \tilde{u} \tilde{i} \tilde{o} \tilde{y} \tilde{o} \tilde{y} \tilde{a} \tilde{y} \tilde{y} \tilde{o} \tilde{i} \tilde{o} \tilde{o} \tilde{e} \tilde{e} \tilde{i} \tilde{i} \tilde{a} \tilde{o} \tilde{u} \tilde{a} \tilde{a} \tilde{y} \tilde{e} \tilde{o} \tilde{a} \tilde{y} \tilde{o}$ ,  $\tilde{c} \tilde{i} \tilde{e} \tilde{e} \tilde{i} \tilde{o} \tilde{y} \tilde{o} \tilde{o} \tilde{n} \tilde{o} \tilde{e} \tilde{o} \tilde{e} \tilde{a} \tilde{a} \tilde{o} \tilde{y} \tilde{c} \tilde{a} \tilde{a} \tilde{a} \tilde{d} \tilde{o} \tilde{o} \tilde{e} \tilde{a} \tilde{a} \tilde{o} \tilde{y} \tilde{o} \tilde{c} \tilde{i} \tilde{d} \tilde{e} \tilde{e} \tilde{a} \tilde{i} \tilde{d} \tilde{c} \tilde{i} \tilde{e} \tilde{e} \tilde{i} \tilde{o} \tilde{a} \tilde{d} \tilde{u} \tilde{o} \tilde{o} \tilde{o} \tilde{e} \tilde{n} \tilde{a} \tilde{i} \tilde{n} \tilde{a} \tilde{i} \tilde{a} \tilde{e} \tilde{u} \tilde{i} \tilde{a} \tilde{d} \tilde{d} \tilde{a} \tilde{a} \tilde{i} \tilde{a} \tilde{a} \tilde{a} \tilde{o} \tilde{a} \tilde{e} \tilde{o} \tilde{o} \tilde{e} \tilde{a} \tilde{e} \tilde{o} \tilde{u} \tilde{a} \tilde{x} \tilde{i} \tilde{y} \tilde{l} \tilde{z} \tilde{e} \tilde{e} \tilde{a}$ .  $\tilde{X} \tilde{a} \tilde{i} \tilde{a} \tilde{e} \tilde{e} \tilde{i} \tilde{a} \tilde{a} \tilde{a} \tilde{c} \tilde{i} \tilde{y} \tilde{y} \tilde{o} \tilde{c} \tilde{o} \tilde{y} \tilde{o} \tilde{d}$ ,  $\tilde{o} \tilde{i} \tilde{i} \tilde{u}$ ,  $\tilde{y} \tilde{i} \tilde{a} \tilde{a} \tilde{i} \tilde{u} \tilde{i} \tilde{a} \tilde{o} \tilde{u} \tilde{a} \tilde{a} \tilde{y} \tilde{e} \tilde{o} \tilde{a} \tilde{y} \tilde{i} \tilde{i} \tilde{e} \tilde{e} \tilde{e} \tilde{c} \tilde{c} \tilde{y} \tilde{e} \tilde{y} \tilde{o} \tilde{n} \tilde{a} \tilde{i} \tilde{a} \tilde{e} \tilde{e} \tilde{d} \tilde{c} \tilde{c} \tilde{e} \tilde{n} \tilde{y} \tilde{i} \tilde{c} \tilde{y} \tilde{h} \tilde{a} \tilde{a} \tilde{t} \tilde{a} \tilde{r} \tilde{s} \tilde{u} \tilde{m} \tilde{y} \tilde{n} \tilde{“} \tilde{X} \tilde{a} \tilde{l} \tilde{i} \tilde{y} \tilde{u} \tilde{n} \tilde{U} \tilde{u} \tilde{l} \tilde{”} \tilde{X} \tilde{X} \tilde{K} \tilde{n} \tilde{y} \tilde{c} \tilde{o} \tilde{d} \tilde{e} \tilde{e} \tilde{i} \tilde{i} \tilde{a} \tilde{o} \tilde{u} \tilde{a} \tilde{3} \tilde{3} \tilde{n} \tilde{a} \tilde{y} \tilde{a} \tilde{o} \tilde{p} \tilde{o} \tilde{1} \tilde{e} \tilde{a} \tilde{5} \tilde{4} \tilde{8} \tilde{0} \tilde{o} \tilde{a} \tilde{a} \tilde{o} \tilde{a} \tilde{o} \tilde{d} \tilde{6} \tilde{o} \tilde{i}$ ,  $\tilde{y} \tilde{i} \tilde{a} \tilde{a} \tilde{i} \tilde{u} \tilde{i} \tilde{a} \tilde{o} \tilde{u} \tilde{a} \tilde{2} \tilde{4} \tilde{.} \tilde{5} \tilde{n} \tilde{a} \tilde{y} \tilde{a} \tilde{o} \tilde{p} \tilde{o} \tilde{1} \tilde{e} \tilde{a} \tilde{4} \tilde{9} \tilde{5} \tilde{0} \tilde{o} \tilde{a} \tilde{a} \tilde{o} \tilde{a} \tilde{o} \tilde{d} \tilde{5} \tilde{.} \tilde{1} \tilde{o} \tilde{i}$ ,  $\tilde{N}_{\zeta} \delta \alpha \alpha \delta \alpha \delta \tilde{n} \tilde{o} \tilde{i} \tilde{u} \tilde{i} \tilde{e} \tilde{d} \tilde{a} \tilde{y} \tilde{i} \tilde{A} \tilde{.} \tilde{Y} \tilde{i} \tilde{o} \tilde{a} \tilde{a} \tilde{o} \tilde{o} \tilde{i} \tilde{i} \tilde{e} \tilde{i} \tilde{u} \tilde{i} \tilde{a} \tilde{o} \tilde{u} \tilde{a} \tilde{4} \tilde{2} \tilde{.} \tilde{5} \tilde{n} \tilde{a} \tilde{y} \tilde{a} \tilde{o} \tilde{p} \tilde{o} \tilde{1} \tilde{e} \tilde{a} \tilde{4} \tilde{9} \tilde{5} \tilde{0} \tilde{o} \tilde{a} \tilde{a} \tilde{o} \tilde{a} \tilde{o} \tilde{d} \tilde{8} \tilde{.} \tilde{5} \tilde{o} \tilde{i} \tilde{-} \tilde{u} \tilde{a} \tilde{a} \tilde{y} \tilde{e} \tilde{o} \tilde{a} \tilde{y} \tilde{a} \tilde{x} \tilde{N} \tilde{y} \tilde{e} \tilde{y} \tilde{i} \tilde{a} \tilde{y} \tilde{i} \tilde{i} \tilde{a} \tilde{A} \tilde{A} \tilde{O} \tilde{O} \tilde{A} \tilde{-} \tilde{u} \tilde{i} \tilde{o} \tilde{a} \tilde{a} \tilde{e} \tilde{o} \tilde{o} \tilde{y} \tilde{e} \tilde{i} \tilde{a} \tilde{o} \tilde{i} \tilde{u} \tilde{c} \tilde{i} \tilde{i} \tilde{d} \tilde{e} \tilde{i} \tilde{a} \tilde{o} \tilde{c} \tilde{y} \tilde{y} \tilde{i} \tilde{a} \tilde{a} \tilde{-} \tilde{o} \tilde{a} \tilde{a} \tilde{a} \tilde{e} \tilde{o} \tilde{o} \tilde{e} \tilde{a} \tilde{i}$ , 2014  $\tilde{i} \tilde{i} \tilde{u} \tilde{o} \tilde{a} \tilde{a} \tilde{d} \tilde{u} \tilde{i} \tilde{o} \tilde{y} \tilde{o} \tilde{y} \tilde{a} \tilde{y} \tilde{y} \tilde{i} \tilde{a} \tilde{i} \tilde{o} \tilde{o} \tilde{e} \tilde{e} \tilde{i} \tilde{i} \tilde{a} \tilde{o} \tilde{u} \tilde{a} \tilde{N}_{\zeta} \delta \alpha \alpha \delta \alpha \delta \tilde{n} \tilde{o} \tilde{i} \tilde{u} \tilde{i} \tilde{o} \tilde{c} \tilde{i} \tilde{n} \tilde{i} \tilde{e} \tilde{e} \tilde{a} \tilde{y} \tilde{e} \tilde{a} \tilde{c} \tilde{o} \tilde{y} \tilde{o} \tilde{d} \tilde{a} \tilde{e} \tilde{i} \tilde{a} \tilde{e} \tilde{e} \tilde{i} \tilde{c} \tilde{a} \tilde{n} \tilde{a} \tilde{a} \tilde{a} \tilde{d} \tilde{a} \tilde{i} \tilde{i} \tilde{2} \tilde{0} \tilde{1} \tilde{2} \tilde{i} \tilde{i} \tilde{u} \tilde{A} \tilde{/} \tilde{3} \tilde{3} \tilde{6} \tilde{o} \tilde{i} \tilde{i} \tilde{o} \tilde{c} \tilde{a} \tilde{o} \tilde{e} \tilde{d} \tilde{a} \tilde{i} \tilde{x} \tilde{y} \tilde{n} \tilde{d} \tilde{a} \tilde{y} \tilde{u} \tilde{o} \tilde{o} \tilde{a} \tilde{a} \tilde{e} \tilde{a} \tilde{a} \tilde{e} \tilde{a} \tilde{o} \tilde{a} \tilde{x} \tilde{e} \tilde{u} \tilde{a} \tilde{c} \tilde{i} \tilde{o} \tilde{e} \tilde{i} \tilde{i} \tilde{a} \tilde{a} \tilde{e} \tilde{x} \tilde{o} \tilde{o} \tilde{e} \tilde{a} \tilde{o} \tilde{b} \tilde{e} \tilde{l} \tilde{t} \tilde{g} \tilde{e} \tilde{l} \tilde{a} \tilde{j} \tilde{l} \tilde{y} \tilde{g} \tilde{x} \tilde{a} \tilde{n} \tilde{g} \tilde{a} \tilde{j} \tilde{a} \tilde{a} \tilde{e} \tilde{i} \tilde{a}$ .

Аймгийн Засаг даргын 2013 оны А/396 тоот “Мал тэжээвэр амьтдын тооллого явуулах тухай” захирамжийн дагуу 2013 оны 12 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд Хушаат, Түшиг сумдад ажиллаж малчдаар түүвэрлэн орж мал тооллогын ажлыг газар дээр нь шалгалаа.

Аймгийн хэмжээнд нийт 258.6 мянган малыг ялган тэмдэглэгээ, бүртгэлжүүлэлтэнд хамруулахаас нийт малын 90.6 хувийг ээмэгжүүлэлт бүртгэлжүүлэлтэд  $\tilde{o} \tilde{a} \tilde{i} \tilde{o} \tilde{o} \tilde{o} \tilde{e} \tilde{x} \tilde{4} \tilde{4} \tilde{.} \tilde{5} \tilde{i} \tilde{y} \tilde{i} \tilde{a} \tilde{i} \tilde{i} \tilde{a} \tilde{e} \tilde{u} \tilde{a} \tilde{a} \tilde{c} \tilde{o} \tilde{o} \tilde{a} \tilde{y} \tilde{e} \tilde{i} \tilde{y} \tilde{a} \tilde{y} \tilde{y} \tilde{e} \tilde{e} \tilde{e} \tilde{i} \tilde{n} \tilde{a} \tilde{i} \tilde{a} \tilde{o} \tilde{a} \tilde{e} \tilde{o} \tilde{d} \tilde{c} \tilde{c} \tilde{y} \tilde{e} \tilde{x} \tilde{i} \tilde{a} \tilde{e} \tilde{y} \tilde{i} \tilde{y} \tilde{a} \tilde{x} \tilde{c} \tilde{c} \tilde{y} \tilde{e} \tilde{x} \tilde{a} \tilde{c} \tilde{o} \tilde{o} \tilde{a} \tilde{y} \tilde{e} \tilde{x} \tilde{c} \tilde{c} \tilde{y} \tilde{o} \tilde{a} \tilde{x} \tilde{e} \tilde{u} \tilde{a} \tilde{y} \tilde{i} \tilde{y} \tilde{i} \tilde{i} \tilde{a} \tilde{a} \tilde{a} \tilde{a} \tilde{a} \tilde{i} \tilde{a} \tilde{c} \tilde{o} \tilde{o} \tilde{n} \tilde{a} \tilde{a} \tilde{o} \tilde{a} \tilde{o} \tilde{d} \tilde{a} \tilde{x} \tilde{e} \tilde{e} \tilde{e} \tilde{a} \tilde{x} \tilde{e} \tilde{a} \tilde{n} \tilde{a}$  байна.

Хүнсний зах, худалдааны төвүүдэд худалдан борлуулагдаж буй 33420 кг мах, махан бүтээгдэхүүний 128 дээж, сүү сүүн бүтээгдэхүүний 19 дээж, үхэр 94, адуу 33, хонь 131, ямаа 30, гахай 19, дайвар бүтээгдэхүүн 11 дээжинд үзлэг шинжилгээ хийж  $\tilde{a} \tilde{d} \tilde{o} \tilde{e} \tilde{o} \tilde{i} \tilde{o} \tilde{y} \tilde{a} \tilde{d} \tilde{e} \tilde{e} \tilde{i} \tilde{a} \tilde{y} \tilde{o} \tilde{-} \tilde{e} \tilde{e} \tilde{a} \tilde{y} \tilde{i} \tilde{e} \tilde{a} \tilde{x} \tilde{a} \tilde{a} \tilde{o} \tilde{a} \tilde{e} \tilde{a} \tilde{a} \tilde{x} \tilde{o} \tilde{o} \tilde{e} \tilde{a} \tilde{e} \tilde{o} \tilde{h} \tilde{i} \tilde{y} \tilde{l} \tilde{z} \tilde{e} \tilde{e} \tilde{a}$ .

## **Зургаа. Газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:**

### **1.Газрын харилцааны талаар:**

“Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд инженерийн барилга, байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах” ажлын гүйцэтгэгчээр “Боригтэс” ХХК шалгарч аймгийн төв Сүхбаатар сумын инженерийн барилга байгууламж, шугам сүлжээг иж бүрнээр хэмжиж бүртгэн, байр зүйн зураглал хийж, мэдээллийн сан байгуулах ажлыг зохион байгуулж байна.

Орхон, Сайхан, Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар сумдын хилийн цэсэд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж Газрын шинэтгэлийн үндэсний хороо, Газрын харилцаа, геодези зураг зүйн газарт тус тус хүргүүлээ.

Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 71 кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж баталгаажууллаа.

### **2.Байгаль орчны талаар:**

Аймгийн Засаг даргын А/355 тоот захирамжаар Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг аймгийн нийт суманд явуулж дүнг нэгтгэн БОНХЯаманд хүргүүлээ. Тооллогоор 2011- 2013 оны тоо бүртгэлээр түүхий нүүрс хэрэглэдэг усан халаалттай зуух 432, галлагаатай өрх 19711, эдгээр зуух жилд 106634 куб метр мод, 473094 тонн нүүрс хэрэглэгдэг аж ахуй нэгж байна.

Аймгийн Засаг даргын 2013 оны А/89, 02 тоот албан даалгавраар “Цэвэр орчин-бидний амьдрал” болзолт уралдааныг 2 сарын хугацаатай зарлаж дүгнэлээ. Цагааннуур сумын иргэн Х.Болд Шилдэг тохижилттой өрхөөр, Цагааннуур, Шаамар, Ерөө, Орхон, Баруунбүрэн сум Цэвэрч сумаар шалгарлаа.

## **Долоо.Сүм орон нутгийн талаар:**

### **1.Баянгол сум:**

Аймгийн Засаг даргын 2013 оны А/360 тоот захирамжийн дагуу сумын Засаг даргын 2013 оны А/210 тоот Гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулах тухай захирамжийн хэрэгжилтийг хангаж, 2013 оны 12 дугаар сарын 2-5-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Сумын Засаг даргын 2013 оны А/209 тоот 2013-2014 оны Соёл мэдээллийн цагийн арга хэмжээ зохион байгуулах тухай захирамжын дагуу сумын төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл өгөх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор спортын арга хэмжээ гэсэн 2 төрлөөр зохион байгуулан, Тус сумын Засаг даргын Тамгын газар, Сэлэнгэ аймаг дахь Архидалт мансуурлын эсрэг ассоциаци, сумын Цагдаагийн хэсэг хамтран архидалт мансуурлын эсрэг сургалтыг зохион байгууллаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймгийн нийгмийн даатгалын хэлтэс, тус сумын Засаг даргын тамгын газар хамтран “Нийгмийн даатгал-таны амьдралын баталгаа” сэдвээр тус сумын иргэдэд сургалт зохион байгууллаа.

Баянгол сумын Засаг даргын Тамгын газар, Дэлхийн зөн олон улсын байгууллага хамтран хүүхдийн шинэ жилийн баярын арга хэмжээг зохион байгуулж, Сайхан сумын Соёлын ордны уран бүтээлчдийн “Үлгэрийн шинэ жил ба өхөөрдөм хөөрхөн бүжин туулай” жүжгийг үзүүллээ.

Мал эмнэлэг үүсэж хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан Батгарьд ХХК, Мэргэн-Онош ХХК, малчид ивээн тэтгэж гар бөмбөгийн тэмцээн зохион байгууллаа. “Гар бөмбөг”-ийн тэмцээнд эрэгтэй 9, эмэгтэй 7 багийн 128 тамирчин оролцож эрэгтэй







Хүүхдийг хуульд заасан эрх, үүргээ хэрхэн ухамсарлан, өөрийгөө болон бусдыг хайрлах талаар ойлголт өгөх зорилгоор “Таны инээмсэглэл, дүүрэн гэгээлэг сэтгэлгээ өөрийгөө болон бусдыг аз жаргалтай болгоно” сэдэвт сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зохион байгууллаа.

“Хушаат сумын хөгжлийн гарц “ сэдэвт зохион бичлэг, гар зургийн уралдааныг тус сумын харьяат, өөр аймаг, суманд амьдарч буй оюутан, залуучуудын дунд 2013 оны 11 дүгээр сарын 20-оос 12 дугаар сарын 20-ыг хүртэл хугацаанд зарлан дүгнэх ажил хийгдэж байна.

### **Найм.Бусад ажлын талаар:**

#### **Стандартчилал хэмжил зүйн хэлтэс:**

Сүхбаатар сумын аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй хэмжих хэрэгсэлд “Хэмжих хэрэгслийн үзлэг тооллого, явуулах тухай” сумын Засаг даргын А/181 тоот захирамжийн тооллогыг хийж 11172 хэмжүүр хэмжих хэрэгсэл тоологдлоо.

Худалдаа үйлчилгээний 28 аж ахуй нэгжид тохирлын үнэлгээ хийж, 18 худалдаа, үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олголоо.

Цагааннуур, Сүхбаатар, Мандал сумын Түнхэл тосгоны 9 аж ахуй нэгж, иргэний 5 нэрийн 16 хүнсний бүтээгдэхүүнийг баталгаажуулалтанд хамруулж, лабораторийн сорилт шинжилгээг үндэслэн баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргалаа. Мөн экспортын бүтээгдэхүүний баталгаажуулалтыг “Алтан тариа” ХХК-ий экспортлож буй хивэгний 9 удаагийн тээвэрлэлтэнд баталгаа гаргаж, тохирлын гэрчилгээ олголоо.

Зүүнбүрэн сумын “Арвин хур” ХХК-ий үйлдвэрлэж буй “Ургамлын тос”, Цагааннуур сумын “Уранцацал” ХХК-ий үйлдвэрлэж буй “Тараг”, “Баян ээж Сэлэнгэ” ХХК-ий үйлдвэрлэж буй “Family” кимчи, Мандал сумын Түнхэл тосгоны “Тулга”, “Өгөөж Ундрэм” талхан цехийн бүтээгдэхүүнүүд улсын стандартын шаардлага хангасан хаяг шошготой боллоо.

Алтанбулаг сумын худалаа, үйлчилгээний газарт болон нэгдсэн эмнэлэгт ашиглагдаж буй 46 жинг ээлжит баталгаажуулалтанд хамрууллаа.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**